

## ЭРДЭНЭ РЕСУРС НЬ БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ЭЦСИЙН ТЭЗҮ-ИЙН ЭЭРЭГ ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАВ

**ТЭЗҮ-д өнөөгийн үнэ цэн ба төслийн дотоод өгөөжийн түвшин өндөр, анхны хөрөнгө оруулалт бага шаардах, өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой уурхайг тодорхойллоо**

### NI 43-101 Техникийн тайлангийн онцлох мэдээлэл (Алтны үнийг US\$1,400/унц төсөөлсөн)

- Суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар болон дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон нь өнөөгийн алтны ханш (US\$1,800/унц)-д тулгуурлан тооцвол тус бүр \$215 сая ам.доллар болон 77% болж өснө.
- Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ-д танилцуулснаар ашиглалтын турш хүү, татвар болон элэгдлийн өмнөх орлого нийт \$257 сая ам.доллар бөгөөд өнөөгийн алтны ханшид тулгуурлавал \$400 сая ам.доллар болж өснө.
- Хөндий Алтны Дүүргийн хөгжүүлэлтийн анхны шатанд нийт 381,700 унц алт олборлоно.
- Нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг (“AISC”) нь \$733 ам.доллар, анхан шатны хөрөнгө оруулалтын хэмжээ \$59 сая ам.доллар
- Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц (“Measured and Indicated Resources”) тодорхойлогдсон
- Мөн 3.71 г/т дундаж алтны агуулга бүхий 409,00 унц батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserves”)-ийг тогтоосон.
- Жилд олборлох алтны дундаж хэмжээ 63,500 унц бөгөөд хоёрдугаар жилд 77,600 унц болж өснө.
- Төслийн үргэлжлэх хугацаа нийт 8-н жил бөгөөд үүнд: уурхай байгуулах 1 жил, Баян Хөндий ордын ашиглалтын хугацаа 6 жил, уурхайн хаалтын хугацааг 1 жил байхаар төлөвлөсөн.
- Эргэн төлөгдөх хугацаа: 2 жил
- Монгол улсад оруулах өгөөж өндөр, уурхайн ашиглалтын хугацаанд Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар (ААНОАТ), Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр (АМНАТ) ба бусад татвар, хураамжид нийт 103 сая ам.доллар төлж, Баянхонгор аймагт 400 гаруй шинэ ажлын байр бий болгоно.

### Хэвлэлийн Мэдээ

Нова Скошиа, Халифакс хот  
2020.07.20

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус эцсийн Техник Эдийн Засгийн Үндэслэл (“ТЭЗҮ” буюу “BFS”)-ийн үр дүнг танилцуулж байгаадаа таатай байна. Энэхүү эцсийн ТЭЗҮ-г NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу боловсруулсан бөгөөд үүнд: нарийвчилсан уурхайн загварчлал, уулын ажлын хуваарь, боловсруулах үйлдвэрийн анхан шатны инженерийн загварчлал (“FEED”), уурхайн дэд бүтэц, гидрогеологийн үнэлгээ, эрдсийн хаягдлын нэгдсэн байгууламжийн загварчлал, хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны дэлгэрэнгүй зардал, тооцоолол болон эдийн засгийн шинэчилсэн загварчлалыг танилцуулсан. Энэхүү тайланг Монгол болон олон улсад үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай олон улсын ба Монголын мэргэжлийн

зөвлөх байгууллагууд хамтран боловсруулав. Техникийн тайланг Roma Group Ltd, ("Roma") NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын ("NI 43-101") дагуу боловсруулж, 45 хоногийн дотор SEDAR-т бүртгүүлнэ.

Компани нь эцсийн ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулах цахим хурлыг 2020 оны 7-р сарын 21-нд 10 цагт ("Зүүн бүсийн цаг" буюу "Eastern Time"), Улаанбаатарын цагаар 2020 оны 7-р сарын 21-нд 22 цагаас зохион байгуулна. Энэхүү цахим хуралд дараах дугаарт залган оролцох боломжтой.

Хойд Америк (үнэ төлбөргүй): 1-877-703-1560

Олон улсын шугам: 1-647-689-5569

Мөн оролцогчид нь дараах линкээр дамжуулан вебкастыг сонсох боломжтой.

<https://onlinexperiences.com/Launch/QReg/ShowUUID=67C7A554-57DF-4DCC-978D-4C232A233C68>

### Компанийн тодруулга:

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ "Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ-д тусгагдсан суурь үзүүлэлтийн үр дүнгүүд нь энэхүү төслийн өндөр өгөөжийг батлан, өсөн нэмэгдэж буй алтны үнэ болон дүүргийн хэмжээнд хийгдэж буй хайгуулын хөтөлбөрүүд нь төслийн тэлэх боломжийг нэмэгдүүлж байна. Газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий Баян Хөндийн ил уурхай нь уламжлалт боловсруулалтын аргаар олборлох боломжтой тул гүйцэтгэлийн эрсдэлийг бууруулан, төслийг хурдацтайгаар хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байна. Хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардал бага, богино хугацаанд буюу хоёр жилийн дотор эргэн төлөгдөх байдал, ирээдүйд тэлэх боломж бүхий Баян Хөндий төслийн олборлолт 2022 онд эхлэхээр төлөвлөсөн бөгөөд өсөн нэмэгдэж буй алтны үнэ нь хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудад эерэгээр нөлөөлж, хөрөнгө оруулалтын хөшүүрэг болох боломжтой."

Петер Акерли үргэлжлүүлэн "Сүүлийн үед хийгдсэн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүн, түүнд багтсан Баян Хөндий ордын Зүүн – өмнөд Мидфийлд ба Баруун-өмнөд Страйкер талбайд илрүүлсэн өндөр агуулга бүхий алтны огтлолууд нь одоогоор бага агуулга бүхий материал хэмээн ангилагдсан байгаа нь төслийн эдийн засгийн үзүүлэлтэд эерэгээр нөлөөлөх боломжтой. Баян Хөндийн хөгжүүлэлт нь хязгаарлагдмал судалгаа хийгдсэн Хөндий Алтны Дүүргийн өсөлтийн суурь бөгөөд нөөцийг тэлэх, уурхайн ашиглалтын хугацааг сунгах зэрэг оролцогч талуудад үнэ цэн бий болгох томоохон боломжийг харж байна. Бид саяхан танилцуулсан хайгуулын амжилтыг үргэлжлүүлэн нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөрийг 2020 оны 3-р улиралд гүйцэтгэх болно."

"Төслийн зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилгоор бид HCF International Advisers Limited ("HCF") компанитай хамтран ажиллаж эхэлсэн. Тэдний туршлага болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("ЕСБХБ" буюу "EBRD") -ийн дэмжлэгээр энэ оны сүүлээр бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх санхүүжилтийг татан төвлөрүүлэх боломжтой." хэмээн танилцууллаа.

### NI 43-101 Техникийн тайлангийн тухай

Техникийн тайлан нь Баян Хөндий төслийн нөөцийн шинэчилсэн тооцооллыг агуулна. Эцсийн ТЭЗҮ-д Баян Хөндийн 3.7 г/т алтны агуулга бүхий 3.4 сая тонн хүдэр багтсан бөгөөд эдгээр нь бүгд батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц ("Proven and Probable Reserves") юм.

Техникийн тайланд газрын дөт гүн дэх өндөр агуулга бүхий Баян Хөндий ордыг ил аргаар олборлохдоо ордын өмнөд хэсгээс хойш (Страйкер болон Алтан Толгой), залгаа орших Мидфийлд болон Зүүн-Хойд Мидфийлд бүсүүдийг үргэлжлүүлэн хойд зүгт чиглэн олборлохоор төлөвлөсөн. Хөгжүүлэлтийн төлөвлөгөө нь уламжлалт нүүрсэнд уусгах технологиор ("CIP") өдөрт дунджаар 1,800 тонн хүдэр боловсруулах үйлдвэрт суурилсан.

Эдгээр тооцооллууд нь алтны үнийг US\$1,400/унц байхаар төсөөлсөн. Мөн тооцооллууд дахь валютыг тусгайлан заагаагүй тохиолдолд Америк доллар (“US\$”) аар тодорхойлогдоно. NI 43-101 удирдамжийн дагуу гүйцэтгэсэн Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ-ийн техникийн тайланг 45 хоногийн дотор SEDAR-т бүртгүүлнэ. Техникийн Тайланд дурдсан голлох үзүүлэлтүүдийг Хүснэгт 1-ээс харна уу.

### Хүснэгт 1. Хөндий Алтны Төслийн онцлох үзүүлэлтүүд

		БХ ТЭЗҮ
Алтны үнэ	US\$/унц	1,400
<b>Үйлдвэрлэлийн үзүүлэлт</b>		
Уурхайн ашиглалтын хугацаанд хүдрийн дундаж агуулга <sup>1</sup>	г/т алт	3.7
Төслийн хугацаа <sup>2</sup>	жил	8
Уурхайн ашиглалтын хугацаа	жил	6
Өдөрт боловсруулах хүдрийн хэмжээ <sup>3</sup>	тонн	1,800
Жилд үйлдвэрлэх алтны дундаж хэмжээ <sup>4</sup>	унц	63,500
Жилд үйлдвэрлэх алтны дээд хэмжээ <sup>4</sup>	унц	79,100
Ашиглалтын хугацааны дундаж металл авалт	%	93%
Хөрс хуулалтын харьцаа (“Strip Ratio”)	тонн:тонн	9.1
<b>Үйл ажиллагааны зардал</b>		<b>БХ ТЭЗҮ</b>
Уурхайн ашиглалтын бэлэн мөнгөөр нэгжийн өртөг <sup>5</sup>	US\$/унц	731
Нэг унц алтны нийт нэгжийн өртөг (“AISC”) <sup>5</sup>	US\$/унц	733
<b>Татварын-өмнөх Өнөөгийн Үнэ Цэн</b>		
5% хорогдуулалттай (“NPV5%”)	сая ам.дол	145
7.5% хорогдуулалттай (“NPV7.5%”)	сая ам.дол	126
10% хорогдуулалттай (“NPV10%”)	сая ам.дол	109
Татварын өмнөх дотоод өгөөжийн түвшин (“IRR”)	%	55%
<b>Татварын-дараах Өнөөгийн Үнэ Цэн</b>		
5% хорогдуулалттай (“NPV5%”)	сая ам.дол	100
7.5% хорогдуулалттай (“NPV7.5%”)	сая ам.дол	86
10% хорогдуулалттай (“NPV10%”)	сая ам.дол	73
Татварын дараах дотоод өгөөжийн түвшин (“IRR”)	%	42%
Эргэн төлөх хугацаа (татварын дараа)	жил	1.9
<b>Хөрөнгө оруулалтын нөхцөлүүд</b>		
Анхны хөрөнгө оруулалт (болзошгүй зардлууд багтсан)	сая ам.дол	59
Ашиглалтын хугацааны хөрөнгө оруулалтуудын зардал	сая ам.дол	5

Тэмдэглэл

1. Боловсруулах үйлдвэрийг тэжээх хүдрийн дундаж агуулга
2. Төслийн хугацаанд бүтээн байгуулалтын 1 жил, олборлолт хийх 6 жил болон уурхайн хаалтын 1 жил багтсан
3. Үйлдвэр нь жилд 8,000 цаг ажиллаж, жилд 600,000 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай байна
4. Үйл ажиллагааны зардал нь Баян Хөндий дээр алтны унцаар тайлагнасан, үүнд \$86/унцаар тооцоолсон Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр (“AMHAT”) болон бусад шимтгэл зардлууд багтсан.

## Техникийн тайлангийн үр дүнгүүд алтны үнээс хэрхэн хамаарах тухай

Доорх хүснэгтэд алтны үнээс шалтгаалан өнөөгийн үнэ цэн (“NPV”) болон дотоод өгөөжийн түвшин (“IRR”) хэрхэн өөрчлөгдөхийг харуулав. Үзүүлэлтүүд алтны үнийн өсөлт бууралт нь төслийн үр дүнд хэрхэн нөлөөлөхийг илэрхийлнэ.

### Хүснэгт 2. Техникийн тайлангийн мэдрэмтгий байдал – Татварын дараах алтны үнийн мэдрэмтгий чанарын судалгаа

Алтны үнийн мэдрэмтгий чанарын судалгаа	Нэгж	\$1,200	\$1,400	\$1,600	\$1,800	\$2,000
NPV (5% хорогдуулалттай)	Сая ам.дол	43	100	158	216	274
NPV (7.5% хорогдуулалттай)	Сая ам.дол	33	86	138	190	242
NPV (10% хорогдуулалттай)	Сая ам.дол	25	73	120	168	215
IRR	%	22%	42%	60%	77%	93%

## Геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийн тооцоолол

Баян Хөндийн геологийн нөөцийн тооцооллыг (“Mineral Resource”) Tetra Tech NI 43-101 болон CIM стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2019 оны 10 дугаар сарын 01-нд батлагдсан тооцоолол юм. Геологийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээллийг 2019 оны 12-р сарын 4-ний өдрийн “Хөндий Алтны Төсөл NI 43-101 техникийн тайлан” -д багтаасан бөгөөд M. Phifer ба C. Norton, Clark, A. Kelly, H. Ghaffari, M. Horan болон M Fawcett (“KGP 2019 Technical Report”) нар боловсруулсан. Энэхүү тайлантай SEDAR дахь Эрдэнэ Ресурсийн хуудаснаас дараах [линкээр](#) танилцах боломжтой ба энэхүү хэвлэлийн мэдээнд лавлагаа болгон дурдав.

Геологийн нөөцийг төлөвлөж буй ил уурхайн ханаар хязгаарлан, хэд хэдэн захын агуулгад тулгуурлан тооцоолсон боловч 0.55 г/т захын агуулгыг ашигласан. Захын агуулгын тооцооллууд болон төсөөллүүдийг Хүснэгт ба тэмдэглэлүүдэд танилцуулсан. Tetra Tech нь Баян Хөндийн геологийн нөөцийн тооцооллыг хэд хэдэн захын агуулгуудын хувьд тооцсон боловч Баян Хөндийн геологийн нөөцийн захын агуулгыг 0.55 г/т үзүүлэлтээр тооцоолохыг зөвлөсөн. Хэмжээ, алтны агуулга зэргийг захын агуулгуудад харьцуулсан хамаарлын мэдрэмтгий байдлын шинжилгээг Хүснэгт 3-т харуулав.

### Хүснэгт 3 – Баян Хөндий Алтны Төсөл – Геологийн нөөцийн тооцооллын хураангуй, 2019 оны 10-р сарын 01

Захын агуулга <sup>(1)</sup>	Ангилал	Хэмжээ (сая т)	Агуулга (Au г/т)	Алт (мян.унц)
0.4	Баттай	1.7	3.15	176
	Бодит	4.6	2.45	364
	<b>Баттай ба Бодит</b>	<b>6.4</b>	<b>2.64</b>	<b>540</b>
	Боломжит	1.1	3.10	106
0.55	Баттай	1.4	3.77	171
	Бодит	3.7	2.93	350
	<b>Баттай ба Бодит</b>	<b>5.1</b>	<b>3.16</b>	<b>521</b>
	Боломжит	0.9	3.68	103
1.0	Баттай	0.7	7.31	153
	Бодит	1.7	5.56	304

	<b>Баттай ба Бодит</b>	<b>2.3</b>	<b>6.05</b>	<b>457</b>
	Боломжит	0.4	6.83	93
1.4	Баттай	0.5	9.09	148
	Бодит	1.4	6.40	294
	<b>Баттай ба Бодит</b>	<b>1.9</b>	<b>7.10</b>	<b>441</b>
	Боломжит	0.4	7.61	91

**Тэмдэглэл**

1. Геологийн нөөцийн тооцооллын тайланг Камерон Нортоны удирдлага дор боловсруулав, тэрээр Tetra Tech-ийн орон тооны ажилтан бөгөөд мэргэшсэн геосудлаач юм. Ноён Нортон хэлэлцэж буй холбогдох ордын эрдэсжилт болон ордын хэв маяг, хэлбэрийн талаар хангалттай туршлагатайгаас гадна CIM-ийн ил тод байдлын стандартад тодорхойлсон Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
2. Дээрх хүснэгтэд тайлагнасан бүх нөөцийн тооцооллууд нь 2019 оны 4-р сарын 22-ны өдөр хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурласан бүхэл тоогоор тоймолсон болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
3. Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
4. Нөөцийн тайлангийн захын агуулгыг 0.55 г/т байхаар тооцсон. Эдгээр захын агуулгын тооцоог Tetra Tech нь ил уурхайн аргаар боловсруулах төсөөлөлд тулгуурлан, алтыг нэг унц нь US\$1,350, ил уурхайн зардал нэг тонн тутамд US\$2 , нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$16, ерөнхий ба захиргааны зардал нэг тонн тутамд US\$5 доллар, алт авалт 95% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан.
5. Нөөцийн тайлан нь алтны үнэ \$2,000 ам.доллар байхад оновчтой уурхайн ханын хязгаараар тооцоологдсон бөгөөд эдийн засгийн өгөөж нь дээрх тооцооллууд дээр үндэслэсэн.
6. Нөөцийн тайланд эрдэсжсэн бүсийн дундаж нягтаршил 2.66 т/м3 байхаар төсөөлсөн.
7. Дээрх геологийн нөөц нь эдийн засгийн тооцоололд ороогүй бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй болно.
8. Баттай ба бодит нөөц нь эдийн засгийн тооцоололд багтахгүй. Боломжит нөөцийг техник эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд хүндрэлтэй. Үйлдвэрлэлийн нөөцөд багтаахгүй.

**Баян Хөндийн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоолол (Reserve Estimate)**

Баян Хөндий , эцсийн ТЭЗҮ-д багтсан нөөцийн тооцооллыг Auralia Mining Consulting-ийн захирал, Мэргэшсэн этгээд Антони Кийрс (“Mr. Anthony Keers”) нь 2014 оны ашигт малтмалын баялаг болон нөөцийн CIM стандартын тодорхойлолтыг ашиглан, NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартад (“NI 43-101”) нийцүүлэн боловсруулсан. Баян Хөндий ордын нийт үйлдвэрлэлийн нөөцийг Хүснэгт 4-д харуулав. Үйлдвэрлэлийн нөөц (“Mineral Reserve”) нь энэхүү хэвлэлийн мэдээнд тусгагдсан 2019 оны 10-р сарын 1-нд шинэчилсэн геологийн нөөц (“Mineral Resource”) -д үндэслэсэн. Үйлдвэрлэлийн нөөцөд батлагдсан болон магадалсан (“Proven and Probable”) нөөцөд шилжүүлсэн баттай болон бодит (“Measured and Indicated”) геологийн нөөц багтсан болно. Уурхайн блокод орох хэмжээ, алтны агуулгыг тооцсон ба нөөцийн тооцоололд бохирдол болон металл авалтын хорогдуулга хийгдсэн. Нөөцийн тайлан 2020 оны 07-р сарын 01-ээс хүчин төгөлдөр болсон.

**Хүснэгт 4. Баян Хөндий Алтны орд – ашигт малтмалын нөөцийн тайлан, 2020 оны 07-р сарын 01**

	Хэмжээ (сая/т)	Агуулга (г/т Au)	Агуулсан Au (мян.унц)
Батлагдсан нөөц	1.2	4.2	166
Магадалсан нөөц	2.2	3.5	244
<b>Үйлдвэрлэлийн Нөөц</b>	<b>3.4</b>	<b>3.7</b>	<b>409</b>

**Тэмдэглэл**

1. Ашигт малтмалын нөөцийн тооцоолол нь 2020 оны 07-р сарын 01-аас хүчин төгөлдөр болсон. Тооцооллыг Мэргэшсэн этгээд Auralia Mining Consulting-ийн захирал, Мэргэшсэн этгээд Антони Кийрс (“Mr. Anthony Keers”) боловсруулсан.
2. Ашигт малтмалын нөөцийн Тооцооллыг 2014 оны Канадын Уул уурхай, Металлург болон Газрын тосны дээд сургууль (CIM) Тодорхойлолтын Стандарт (2014 CIM Тодорхойлолтын Стандарт) болон 2003 оны CIM Шилдэг Практик Удирдамжийн дагуу бэлтгэсэн.
3. Нөөцийг ил уурхайн аргаар олборлоно гэж тооцоолсон

4. Хаягдал болон хүдрийн захын хязгаарыг моделийн блок бүрийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрт тулгуурлан тооцсон. БЦАТ-ийг уурхайн бус алдагдал, тээвэрлэлт, хайлуулах болон цэвэршүүлэх зардлуудад тулгуурлан тооцоолсон.
5. Нөөцийг тооцоолохдоо нэг унц алтны үнэ \$1,400 ам.доллар төсөөлөл дээр үндэслэсэн.
6. Ашигт Малтмалын Нөөцөд 9% бохирдолт болон 1% алдагдал багтсан.

## Олборлох аргачлал

Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ нь жилд 600,000 тонн хүдрээр үйлдвэрийг тэжээх хүчин чадал бүхий ил уурхайд тулгуурласан. 3.7 г/т алтны дундаж агуулга бүхий 3.4 сая тонн олборлох боломжтой хүдэр багтсан бөгөөд, хөрс хуулалтын харьцаа 9.1:1 байна (тонн хаягдал: тонн үйлдвэр тэжээх хүдэр). Эрдэжилт нь газрын дөт гүнд буюу хүдрийн дийлэнх хэсэг нь газрын гадаргаас доош 100 метрийн гүнд байна. Ордыг структур, агуулга болон гүнээс шалтгаалан ил уурхайн аргаар ашиглах боломжтой. Ашиглалтын үед урвуу хутгуурт гидравлик экскаватор ашиглана. Тэсэлсэн хөрс, материалыг автосамосвалд ачин, хаягдал материалыг уурхайтай залгаа орших нэгдсэн хаягдлын байгууламжид ("IWF") хуримтлуулан, хүдрийг боловсруулах үйлдвэрийн дэргэдэх тээрэм эсвэл хүдрийн овоолго ("ROM") руу шилжүүлнэ.

Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ-д нь ижил төстэй ил уурхайн олборлолтын орчинд Монголд зохих туршлагатай гэрээлэгчдээс ирүүлсэн саналд тусгагдсан аргачлал болон зардалд үндэслэн гэрээт олборлолтыг хийхээр төлөвлөсөн. Энэ тохиолдолд гүйцэтгэгч нь төслийн үнийн хуваарийг үндэслэн бүрэн ажиллах хүч болон хүний нөөцөөр хангана (ам доллар/тонн материалын зөөлт). Гүйцэтгэгч нь 4 х экскаватор (2 х хүдэр, 2 х хаягдал), 10 х 55 тонн даацтай автосамосвал, 3 х тэсэлгээний өрөм, шаардлагатай материалын зөөврийн нэмэлт ба туслах хэрэгслийг санал болгосон. Олборлолтын хуваарийн шаардлагыг ханган ажиллахын тулд гүйцэтгэгч нь хамгийн дээд тал нь дунджаар 190 ажилтантай ажиллана.

## Боловсруулалт

Эцсийн ТЭЗҮ-д овоолгын хүдрийн материалыг боловсруулахдаа уламжлалт буюу бутлан, тээрэмдэж, баяжуулан, нүүрстэй уусгах технологиор алтыг ялгаж авахаар төлөвлөсөн. 360-Global нь боловсруулах үйлдвэрийн загварчлалыг Blue Coast Research-ийн боловсруулалтын үзүүлэлтийн оновчлол зэрэг судалгаанд тулгуурлан тодорхойлсон. Энэхүү оновчлолд 60 микронд хүрэх 80% хүртэл бутлах, нунтаглах мөчлөгийн өгөгдлийн загварчлал, баяжуулах мөчлөгийн бага цианидийн баяжуулалт (0.5 г/литр натрийн цианид); 36 цагийн хадгалалт, нүүрсэнд шингээх үзүүлэлтүүд, хоргүйжүүлэх урвалжийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүд багтсан. Боловсруулах мөчлөг нь усны нөхөн сэргээлтийг хамгийн өндөр түвшинд байлгах, усгүйжүүлэх үйл явцыг хамгийн үр дүнтэй буюу хаягдлын чийгшлийг 15%-д байлгах, химийн болон урвалжийн хэмжээг бууруулж, байгаль орчны нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах аар төлөвлөгдсөн.

Хүдэр боловсруулах үйлдвэрийг Баян Хөндийн ил уурхайтай зэрэгцээ барих бөгөөд өдөрт 1,800 тонн хүдэр, жилд 600,000 тонн хүдэр боловсруулна. Уурхайн ашиглалтын хугацаанд 3.7 г/т дундаж агуулга бүхий нийт 3.4 сая тонн хүдрийг боловсруулна. Төслийн хугацаанд металл авалт 93.1% байх бөгөөд Баян Хөндий ордоос нийт 381,700 унц алт үйлдвэрлэнэ.

## Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардлыг дээр дурдсан олборлолтын болон боловсруулалтын хувилбарууд дээр үндэслэн, гэрээт олборлогчтой хамтран ажиллахаар тооцоолсон. Үйл ажиллагааны эрчим хүчийг дизель болон нарны эрчим хүчийг хослуулан, төслийн хугацаанд хийсэн эрчим хүч худалдан авах гэрээний дагуу хангана. Бусад зардлуудыг компани хариуцан ажиллана. Баян Хөндий төслийн хувьд унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг \$733 ам.доллар/унц байхаар тооцоолсон.

**Хүснэгт 5. Үйл ажиллагааны зардал**

	LOM (сая ам.дол)	Ам.дол /унц	Ам.дол/ тонн
Олборлолтын зардал	133	350	39
Боловсруулалтын зардал	96	252	28
Ерөнхий ба захиргааны зардал	13	33	4
Нийт үйл ажиллагааны зардал	242	635	71
Нөөц ашигласны төлбөр & бусад зардал	33	86	10
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт ба уурхайн хаалтын зардал	5	12	1
Алт үйлдвэрлэх нэгжийн өртөг	280	733	82

**Хөрөнгийн зардал**

Уурхай байгуулалт, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны хөрөнгийн зардлыг (0 жилд) 48 сая ам.доллар хэмээн тооцоолсон. Үйлдвэрлэлийн өмнөх зардал нь 8 сая ам.доллар болохоор тооцоолсон. Үүнд бүтээн байгуулалтад бэлдэх, уурхайн хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон хөрс хуулалтын өмнөх зардал багтсан. Хөрөнгийн зардлын тооцоонд 10% болзошгүй зардлыг шингээсэн. Тогтвортой хөрөнгө оруулалтад 4 сая ам.доллар, үлдэгдэл өртгийг багтаасан хаалтын зардалд 1 сая ам.долларыг тусгасан. Баян Хөндий Алтны Төслийн ашиглалтын хугацааны нийт хөрөнгийн зардлыг 64 сая ам.доллар хэмээн тооцов.

**Хүснэгт 6. Хөрөнгийн зардал**

Зүйл	(\$ сая ам.дол)
Баяжуулах үйлдвэр	24
Үйлдвэрээс бусад дэд бүтэц	10
Байр, орон сууц	2
Барилга байгууламжийн шууд бус зардал	6
Инженерчлэл ба бусад	4
<b>Бүтээн байгуулалтын зардал</b>	<b>46</b>
Олборлолтын өмнөх зардал	8
Болзошгүй зардал	5
<b>Боловсруулах үйлдвэр ба дэд бүтэц нийт</b>	<b>59</b>
Тогтвортой хөрөнгө оруулалт	4
Байгаль орчин ба уурхайн хаалт	3
Үлдэгдэл өртөг	(2)
<b>Нийт</b>	<b>64</b>

Тэмдэглэл: Дээрх өгөгдлүүдийг бүхэл тоонд тоймлосон нь тооцооллын зөрүү үүсгэх магадлалтай.

**Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжууд**

Хөндий Алтны Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжууд:

- Баян Хөндийн нөөцийг тэлэх:

- Баян Хөндийн нөөцөд 3.16 г/т алт дундаж агуулгатай 521,000 унц баттай болон бодит нөөц багтдаг. Баян Хөндийн нөөцийн тооцоололд нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн нөөц рүү шилжүүлэх боломжтой 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит геологийн нөөц багтсан.
- Зүүн-өмнөд Мидфийлд ба баруун-өмнөд Стайкер талбайд гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүнд 582 г/т алтны агуулга бүхий 1 метр багтаасан 126 г/т алтны агуулга бүхий 5.5 метрийн интервал зэрэг өндөр агуулга бүхий алт огтолсон нь одоогоор бага агуулгатай материалд ангилагдаж байна. Ашиглалтын эхэн үед эдгээр талбай нь нэмэлт өндөр агуулга бүхий хүдрээр хангах боломжтой.
- Түүнчлэн, ордын баруун Стайкер талбайд хийсэн өрөмдлөгөөр өндөр агуулга бүхий алтны агуулга ажиглагдсан нь үргэлжилж буйг шалгахар цооногийн зайг ойртуулж өрөмдсөнөөр нэмэлт өндөр агуулга бүхий нөөцийг тэлэх боломжтой.
- Танилцуулсан нөөц нь алтны үнийг \$1,350 ам.доллар, болон бусад уурхайн үзүүлэлт дээр (Хүснэгт 1, тодруулга 4) тулгуурлан тооцоолсон. Алтны үнэ өсч буй үед ил уурхайн хязгаарын гадна буй хэд хэдэн өндөр агуулга бүхий интервал огтолсон талбайд нэмэлт өрөмдлөг хийх шаардлагатай.
- Баян Хөндийн төслийн талбайд өндөр агуулга бүхий материалыг баталгаажуулах нэмэлт өрөмдлөгүүдийг 2020 оны 3-р улиралд гүйцэтгэхээр төлөвлөсөн.
- Хайгуул: Баян Хөндий орд нь хайгуул хязгаарлагдмал хийгдсэн, хэтийн төлөв сайн бүсэд оршдог. 2019 онд нээн илрүүлсэн Хар Морь талбай болон Баян Хөндийн ордоос 4 км зайд дөт гүнд хийгдсэн судалгаа болон гадаргын дээжлэлтээр хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон.
  - Эрдэнэ Ресурс нь Хар Морь талбайд 50.8 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 8.8 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал, 45.3 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 14 г/т 4 метрийн интервал багтаасан сорьцлолтуудыг илрүүлснээр энэхүү бүсэд шинэ алтны талбайг нээв. Хар Морь талбайд хязгаарлагдмал судалгаа хийгдсэн бөгөөд 1.3 км структурын трендийн дагуу зүүн хойд зүгт судлын дагуу нарийн тодорхойлогдон үргэлжилсэн хөрсөн дэх алтны аномаль байх боломжтой нь энэхүү талбай нь өндөр хэтийн төлөвтэй болохыг илэрхийлнэ. Түүнчлэн, Зүүн-хойд, баруун-хойд структурын огтлолцол дээр/ойролцоо хэд хэдэн тусгаарлагдсан боловч хүчтэй хувирсан хөрсөн дэх алтны аномаль байгааг тодорхойлсон. 2020 оны 3-р улиралд өрөмдлөгийн хөтөлбөрийг хийж гүйцэтгэнэ.
- Металл авалтыг нэмэгдүүлэх: Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ-д металл авалтыг 93% хэмээн тусгасан боловч Баян Хөндийн хүдрийг төлөөлөх 3.6 г/т алтны агуулга бүхий хүдрийг шалгаж үзэхэд дундаж металл авалт 95% байсан нь боловсруулах явцад металл авалтыг нэмэгдүүлэх боломжтой.
- Өндөр агуулга: Баян Хөндий орд нь өндөр агуулга бүхий орд бөгөөд цаашид ашиглалтын шатанд тооцоолсноос өндөр агуулгатай бүсийг нээн илрүүлэх магадлалтай гэж үзэж байна.
- Далд уурхайн боломж: Далд уурхайн боломжийг судлах судалгааны үр дүнд Хойд Мидфийлд болон Баруун Стайкер талбайг тодорхойлсон бөгөөд хэрвээ эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзвэл Баян Хөндий Төслийн эдийн засгийн нөөцийг нэмэгдүүлэх боломжтой.
- Алтан Нар дахь нэмэлт нөөц:  
Баян Хөндий ордоос хойш зүгт ойролцоогоор 16 км-ийн зайд орших Алтан Нар ордод 2.0 г/т алтны агуулга бүхий 5.0 сая тонн бодитой геологийн нөөц (318,000 унц алт), 1.7 г/т алтны агуулга бүхий 3.4 сая тонн боломжтой геологийн нөөц (186,000 унц алт) тооцоологдсон. Алтан Нар ордын нөөцийн 250,000 унцыг Баян Хөндий төслийн боловсруулах үйлдвэрт харьцангуй бага зардлаар боловсруулах боломжтой (KGP 2019 Техникийн тайлантай танилцана уу). Алтан Нар ордыг хөгжүүлэх боломжуудыг тодорхойлж байна.



## Байгаль орчин ба Тусгай зөвшөөрөл

2020 оны 06-р сард, Эрдэнэ Ресурс нь хараат бус Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“ЕСБХБ”, “EBRD”)-ын Гүйцэтгэгэлийн Шаардлагын дагуу боловсруулсан. Судалгааг Sustainability East Asia LLC (“SEA”) тэргүүлж, Ramboll Australia Pty Ramboll (“Ramboll”) болон Eco Trade LLC (“Eco Trade”) хамтран боловсруулсан. Үүнтэй зэрэгцэн Монгол улсын хууль эрхзүйн шаардлагад нийцсэн Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээний (“БОНБНУ”) -г Эко Трейд ХХК боловсруулсан. БОНБНУ-ний орон нутгийн иргэдийн хэлэлцүүлгийг 2020 оны 3-р улиралд хийхээр төлөвлөж байна. Хэлэлцүүлгийн дараа компани нь хууль тогтоомжийн дагуу БОНБНУ-г батлуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлнэ.

Эрдэнэ Ресурс нь өнгөрсөн жилийн хугацаанд Баян Хөндий Алтны төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай гол зөвшөөрлүүдийг авсан. 2019 оны 8-р сард 30 жилийн хугацаатай Баян Хөндийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд уг тусгай зөвшөөрлийг 70 жил хүртэл хугацаагаар сунгах боломжтой. Түүнчлэн, Компанийн Техник, Эдийн Засгийн Үнэлгээ (“Монгол ТЭЗҮ”) -г 2020 оны эхээр Ашигт Малтмал, Газрын Тосны Газар баталгаажуулсан. Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Хөндий Алтны Төслийн хүрээнд төлөвлөсөн боловсруулах үйлдвэр, дэд бүтцэд ашиглах усны нөөц, урсцын хэмжээг баталгаажуулсан. Төслийн Газар Зохион Байгуулалтын Ерөнхий Төлөвлөгөөг орон нутгийн захиргааны байгууллага баталж, ил уурхай болон холбогдох газрын дэд бүтцийг барихад шаардагдах 100 га талбайн зөвшөөрөл олгосон. Барилга угсралтын зөвшөөрлийг Монгол БОНБНУ батлуулсны дараа авахаар хүлээгдэж байна.

## Төслийн Санхүүжилт болон Дараагийн Алхмууд

Компани нь зээлийн санхүүжилт төвлөрүүлэх зорилгоор Төслийн Санхүүжилтийн Зөвлөх HCF компанитай хамтран ажиллаж байна. HCF нь олон улсын байгалийн нөөц, дэд бүтцийн салбарт төвлөрөн ажилладаг, Их Британийн Лондон хотод төвтэй, санхүүгийн зөвлөх үйлчилгээний чиглэлээр тэргүүлэгч хараат бус байгууллага юм. HCF нь төслийн мөчлөгийн аль ч үе шатанд стратегийн болон санхүүгийн зөвлөгөө, зээлийн санхүүжилтийн төлөвлөлтөд хамтарч ажилладаг. HCF нь Монгол Улс дахь хамгийн том уул уурхайн төсөл болох Оюу Толгойн санхүүжилтийн зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай, мөн Эрдэнэ Ресурсийн стратегийн хөрөнгө оруулагч болон Монгол улсын томоохон хөрөнгө оруулагчдын нэг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банктай (“ЕСБХБ”) хамтран ажилладаг. HCF нь Эрдэнэ Ресурстай хамтран 2020 оны эцэст төслийн санхүүжилтийн багцыг баталгаажуулахаар ажиллаж байна. Төслийн бэлэн мөнгөний урсгалыг харгалзан нийт санхүүжилтийн 70%-ийг зээлийн санхүүжилтээр хийхээр төлөвлөж байна.

Ирэх саруудад төслийн санхүүжилтээс гадна дараах хөгжүүлэлтэд төвлөрөн ажиллана.

- Эрдэнэ Ресурсийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авах;
- БОНБНУ-г гүйцэтгэж, барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авах;
- Баян Хөндийд өрөмдлөгийн хөтөлбөр эхлүүлэх, үр дүнгүүдийг шинэчилсэн нөөцөд багтаах;
- Худалдан авалт болон тусгай зөвшөөрлүүдийг багтаасан төслийн гүйцэтгэлийн хуваарийг оновчтой болгох;
- Одоо байгаа зөвшөөрлийг шинэчлэх, хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримтыг боловсруулах, шаардагдах нэмэлт зөвшөөрөл авах хүсэлт гаргах;
- Нарийвчилсан инженерчлэл болон загварчлалыг боловсруулах;
- Бүтээн байгуулалтыг дэмжих ажлуудыг эхлүүлэх зэрэг ажлууд багтаж байна.

## ТЭЗҮ боловсруулахад оролцсон зөвлөх байгууллагууд

Эцсийн ТЭЗҮ ба анхан шатны инженерийн загварчлал (“FEED”) -ын судалгаануудыг Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай олон улсын болон Монголын зөвлөх байгууллагууд хамтран боловсруулсан:

- Рома Групп Лтд (“Roma”) нь инженерчлэл, бизнес болон хөрөнгийн үнэлгээ, эрсдэлийн тооцоолол болон компанийн үнэлгээ, нэгдэл зэрэг үйл ажиллагаанд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг бүс нутгийн тэргүүлэх байгууллага юм. Рома нь NI 43-101 стандартын дагуу эцсийн ТЭЗҮ-ийг боловсруулахаас гадна гидрологи - гидрогеологи, геотехникийн судалгаа, зардлын тооцоолол, санхүүгийн загварчлалыг гүйцэтгэсэн. Рома нь Хонг Конгийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компани бөгөөд Монгол болон олон улсад уул уурхай, санхүүгийн байгууллагуудтай техникийн судалгаа, үнэлгээний төслүүдийг удирдан ажилласан туршлагатай.
- Эцсийн ТЭЗҮ, анхан шатны инженерийн загварчлалын тайланг боловсруулахад дараах дотоодын компаниуд хамтран ажилласан. Үүнд: геотехник инженерчлэлийн Соил Трейд ХХК (“Soil Trade”), инженерчлэл болон барилга байгууламжийн Лобо Эрдэнэ ХХК (“LOBO”), уурхайн инженерчлэлийн зөвлөх байгууллага Прожект Майнинг ХХК (“Project Mining”), байгаль орчны зөвлөх байгууллага Эко Трейд ХХК (“Eco Trade”) багтаж байна. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын хууль, дүрэм журмуудад нийцүүлэн үйл ажиллагааны бүхий л үе шатанд дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг чухалчилсаар ирсэн.
- O2 Майнинг Лтд (“O2”) нь уурхайн төлөвлөлт ба загварчлал (уурхайн хаалт багтсан) дээр хамтран ажилласан бөгөөд Монголын барилгын тусгай зөвшөөрлүүд, боловсруулалтын бус дэд бүтцийн төлөвлөлтийг багтаах анхан шатны инженерийн загварчлал (“FEED”)-ыг хамтран боловсруулсан. O2 нь Хонг Конг-д төвтэй, Австрали, Азийн бүс нутагт уурхай хөгжүүлэлтийн чиглэлээр мэргэшсэн компани бөгөөд Монгол улсад +13 жилийн турш үйл ажиллагаа явуулж буй алт болон нүүрсний уурхайн ашиглалт, үйл ажиллагаа, загварчлал, бүтээн байгуулалтад оролцсон туршлагатай компани юм.
- Ауралиа Майнинг Консалтинг (“Auralia”) нь эрдсийн нөөцийн эцсийн загварчлал болон уурхайн загварын оновчлолыг гүйцэтгэсэн. Ауралиа нь Австрали улсын Перт хотод төвтэй уурхайн инженерчлэл, нөөцийн тооцоолол зэргээр мэргэшсэн зөвлөх байгууллага бөгөөд Баррик (“Barrick”), Гоулд Роуд Ресурсиз (“Gold Road Resources”) зэрэг алтны компаниудтай хамтран ажиллаж байсан туршлагатай компани юм.
- 360-Глобал Инк (“360-Global”) нь эцсийн ТЭЗҮ, анхан шатны инженерийн загварчлалд багтах баяжуулах үйлдвэрийн загварчлал, инженерчлэлийн судалгааг хийж гүйцэтгэсэн. 360-Глобал Инк нь Австрали, Филиппин улсуудад төвтэй бөгөөд Монгол болон БНХАУ, Канад, Австрали болон Африк-т алтны боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн загварчлал хийх үйлчилгээ үзүүлдэг туршлагатай байгууллага юм.
- Эй Ти Си Виллиамс РТУ Ltd (“ATCW”) нь эрдсийн хаягдлын байгууламж, удирдлага болон уурхайн хаалтын төлөвлөлтийг боловсруулсан. ATCW нь Австралийн Мелбурн хотод төвтэй бөгөөд Оюу Толгой зэрэг төслүүдэд хаягдлын тээвэр, хадгалалт, хаалт болон усны удирдлага зэрэг үйлчилгээ үзүүлсэн туршлагатай.
- Blue Coast Research Ltd (“BCR”) нь Хөндий Алтны Төслийн металлургийн судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн. BCR нь алтны ордуудын судалгааг хийж гүйцэтгэж байсан туршлагатай бөгөөд өнөөг хүртэл Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн металлургийн судалгааг гүйцэтгэж байна.

Sustainability East Asia, Ramboll, Эко Трейд компаниуд нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг 2020 оны 6 сарын 4-нд танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй дараах [линкээр](#) танилцана уу)

## Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Энэхүү хэвлэлийн мэдээнд багтсан Баян Хөндийн ТЭЗҮ-ийн санхүүгийн загвартай холбоотой мэдээлэл нь ROMA Group Ltd-ийн ажилтан Кэнни Ли, CFA (Kenny Li)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд суурилсан болно. Энэхүү хэвлэлийн мэдээ дэх Баян Хөндийн ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны зардлын тооцоотой холбоотой мэдээлэл нь FAusIMM ба O2 Mining Ltd компанийн захирал Жулиен Лауренс (Julien Lawrence)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд суурилсан болно. Энэхүү хэвлэлийн мэдээ дэх Баян Хөндийн ТЭЗҮ-ийн боловсруулах үйлдвэрийн загварчлал болон алт авалтын аргачлалтай холбоотой мэдээллийг FAusIMM-ийн гишүүн ба O2 Майнинг ХХК-тай хамтран ажилладаг Жеффри Жардин (Jeffrey Jardine)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд үндэслэсэн болно. Хэвлэлийн мэдээ дэх Баян Хөндийн нөөцийн тооцооллыг Tetra Tech-ийн ажилтан Кам Нортон (“Cam Norton”), P. Geo, боловсруулж, баталгаажуулсан. Баян Хөндийн үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллыг Auralia Mining Consulting-ийн захирал Антони Кирс (Anthony Keers) (MAusIMM CP Mining), боловсруулж баталгаажуулсан. Ноён Ли, Лауренс, Жардин, Нортон ба Кирс нар нь энэ төрлийн орд болон эрдэсжилтийн төрлийн талаар мэдлэг туршлагатай, NI 43-101-т тодорхойлсон мэргэшсэн мэргэжилтнүүд юм. Ноён Ли, Лауренс, Жардин, Нортон ба Кирс нар нь Эрдэнэ Ресурстай холбоотой ашиг сонирхлын зөрчил байхгүй болно.

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P. Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

## Хөндий Алтны Төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардагас хоорондоо 16 км зайд орших

Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц (“Measured and Indicated Resources”), 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтаж байна. Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

## Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 3 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

## Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь Англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

## Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>